

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ БАТАТГАХ ХОЛБООС, ТҮҮНИЙ УТГА, ХЭРЭГЛЭЭ

Г.Баттогтох


Түлхүүр үг: *холбоосжилт, холбоос, өргөжүүлбэр, нарийвчилбар, бататгах холбоос, өөрөөр хэлбэл*

1. Удиртгал. Аливаа юм үзэгдэл, түүний харьцаа хөдөлгөөн нь төгс санааг илэрхийлэх бөгөөд өгүүлбэр, хэд хэдэн төгс санааны нийлэмжийг эх гэнэ. Төгс нэгж нь бүтээвэр, үг, холбоо үг зэрэг төгс бус дохионы өөр хоорондоо харьцаанд буй цогц юм. Тэрхүү харьцааг холбох нэгэн гол хэрэглүүр нь эх судлалын үндсэн судлагдахуун болох холбоос юм.

М.А.К.Халлидэй (М.А.К.Halliday), Рукайяа Хасан (Ruqaiya Hasan) нар эхийн холбомжилт (cohesion)-ийн тогтолцоог судалж, “Англи хэл дэх холбоосжилт” (Cohesion in English) хэмээх номыг 1976 онд бичиж хэвлүүлжээ. Тэд уг бүтээлдээ холбоосын тухай үндсэн ойлголт (The concept of cohesion), төлөөлүүлэл (reference), орлууулал (substitution), орхилт (ellipsis), холбоос (conjunction), үгийн сангийн холбоосжилт (lexical cohesion) зэрэг асуудлыг хөндөн судалсан байна. Үүнээс холбоосыг утгын хувьд нэмэлт холбоос (additive), салгах холбоос (adversative), шалтгааны холбоос (causal), цагийн холбоос (temporal) гэсэн 4 үндсэн хэлбэрт хуваан үзэж, судлан шинжилжээ (1976: 238-267).

М.А.К.Халлидэй, Кристиан Маттэйссэн (Christian Mattiessen) “Үүргийн хэл зүйн удиртгал” (An Introduction to Functional Grammar) хэмээх номдоо өмнөх саналаа лавшруулж, “Илтгэх урлагийн бүтцийн онол” (Rhetorical structure theory) (Манн, Томсон нар, 1992: 39-79)-д тулгуурлан, холбоосын тогтолцоо (The system of conjunction)-г судлан боловсруулжээ (2014: 611-622). Тиймээс энэхүү тогтолцооны дагуу монгол хэлний холбоосыг ангилах, хэлний түвшинд гүйцэтгэх үүрэг харьцааг нь нягтлах, эхийн хэлбэр төрөлд илрэх утгыг нь тайлбарлах шаардлагатай юм.

2. Нарийвчилбар. М.А.К.Халлидэй нарын боловсруулсан *холбоосын тогтолцоо* дараах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Үүнд:



Нарийвчилбар хэсэгт хавсаргах холбоос (apposition) болон тодруулах холбоос (clarification)-ыг багтаан үзнэ. “Хавсаргах холбоос” дэд хэсгийг бататгах (expository), жишээлэх холбоос (exemplifying); “тодруулах холбоос” дэд хэсгийг магадлах (corrective), ташрамдах (distractive), чөлөөлөх (dismissive), онцлох (particularizing), хураах (resumptive), сэргээх (summative), нотлох холбоос (verifactive) гэж ангилна.

Төгс, төгс бус нэгжийн араас утгыг нь нарийвчлан тайлбарлаж бататгах зорилготой, өөр нэгэн төгс, төгс бус нэгжийг үгээр холбон хавсаргаж болно.

3. Бататгах холбоос. Холбоос гэдэг нь аливаа эхийн уялдаа холбоотой хоёр хэсгийг нэгтгэж, цогц болгон хувиргахыг хэлнэ (Томсон, 2014: 225). Энэхүү өгүүлэлд холбоос, түүний нэгэн гол хэсэг: нарийвчилбарын баримт болгон $[A = B]$ бүтэц (төгс дохио = төгс дохио, төгс дохио = төгс бус дохио, төгс бус дохио = төгс бус дохио) бүхий хоёр дохиог нарийвчилж холбох үндсэн үүрэгтэй *өөрөөр хэлбэл* холбоос, түүний хувилбар: *ондоогоор хэлбэл, нөгөөгөөр хэлбэл, өөр үгээр хэлбэл, өөр утгаар хэлбэл* зэрэг холбоос; А дохиог В дохиогоор хэрэглээний орчин нөхцөлд нийцүүлэн тайлбарлаж бататгах үүрэгтэй *ухаандаа, хар ухаанаар хэлбэл, хэлэх зүйл маань, миний бодлоор* зэрэг холбоосыг тайлбарлав.

*Өөрөөр хэлбэл*¹ гэдэг холбоос нь юм үзэгдэл, түүний харьцаа хөдөлгөөнийг өөр дохиогоор тайлбарлах үүрэгтэй, дагалдуулсан шинжтэй холбоос юм. Уг холбоосын шинж нь хэлний түвшин, найруулгын хэрэглээнээс хамаарч харилцан адилгүй байна. Д.Отгонсүрэн “буюу”, “өөрөөр хэлбэл” холбоос чанарын хувьд нэг л юмыг зааж холбодог тул нэгтгэх (нэг болохыг заах) үүрэгтэй байна” (1978: 20) гэж үзсэн бол Б.Пүрэв-Очир монгол хэлний “ A_1 - буюу - A_2 ”, “ A_1 - өөрөөр хэлбэл - A_2 ” гэсэн загварт бүтэцтэй, нийлэмжүүдийг ажиглавал, $A_1 \dots A_2$ гэсэн хоёр бүрэлдүүлбэр нь адил тэнцүү чанартай мэдээллийг агуулсан, нэг нь нөгөөгөө тодосгон, нэг бол дэлгэрүүлж, эсвэл хурааж тайлбарлаж онцолсон шинжтэй, бас ерөнхийдөө ижил төстэй утга санааг илэрхийлсэн, хам бүтцийн талаасаа өөрчлөн хувиргаж хийсэн нэгэн өвөрмөц давталтын шинжтэй, бас нэг нь нөгөөгөө орлох үүрэгтэй тийм өвөрмөц онцлогийг хадгалдаг зүй тогтолтой байна гэж үзэв (2005: 59-60) гээд хэлбэржсэн үгээс хүүрнэмж, тайлбарламж, тоочимж, эргэцүүлэмж, эх болох цогцолборын найруулгад гүйцэтгэх үүрэг, зорилго, утга санааг нь жишээлэн тайлбарлажээ.

Юм үзэгдлийг дангаар нь заасан төгс бус дохио болох үглэврийг өөр төгс бус дохио болох үглэвэртэй *өөрөөр хэлбэл* холбоосоор холбон тайлбарлаж болно. Энэ тохиолдолд хоёр үглэвэр харилцан ижил утгыг илтгэх бөгөөд хоёр дахь үглэвэр нь юм үзэгдлийн ерөнхий нэршлийг агуулсан учир эхний үглэвэрт хавсаргаж бататгасан үүрэгтэй байна. Тиймээс шинжлэх ухааны эх, түүний нэр томъёог тайлбарлах зэрэгт уг хэлбэрийг ашиглан бичвэл агуулгыг тодорхой болгох, хоёрдмол утга үүсэхгүй байх нөхцөл бүрдэнэ. Жишээ нь: *үе-утгалбар, өөрөөр хэлбэл язгуур бүтээвэр*. Түүнчлэн уул холбоосоор үглэврийг өгүүлбэр, цогцолбортой холбоход дэлгэрүүлж бататгах; өгүүлбэрийг үглэвэртэй холбоход хурааж бататгах, өгүүлбэрийг өгүүлбэртэй холбоход тэнцүүлж бататгах, өгүүлбэрийг цогцолбортой холбоход дэлгэрүүлж бататгах; цогцолборыг үглэвэр, өгүүлбэртэй холбоход хурааж бататгах, цогцолборыг цогцолбортой холбоход тэнцүүлж тайлбарлаж буй ерөнхий утгыг илэрхийлж байна. Холбож буй төгс ба төгс бус нэгжийн утга, харьцаанаас хамаараад жиших, харьцуулах, хувиргах, хялбаршуулах, дүйлгэх, давтах зэрэг нарийвчилсан утга илэрнэ.

¹ Б.Пүрэв-Очир монгол хэлний холбоос үгийн бүтэц, утга, үүрэг, хэрэглээний тухай хэд хэдэн өгүүлэл бичжээ. Тэрээр буюу холбоос нь *өөрөөр хэлбэл*-тэй утга ба үүргээрээ тун ойролцоо нь ажиглагддаг. Өөрөөр хэлбэл, буюу-г зарим тохиолдолд *өөрөөр хэлбэл*-ээр солин найруулах боломжтой байдаг (2005: 58) гээд оруулбар нэгжийн байдалтай хэрэглэгддэг, тайлбарлах утга бүхий холбох үг гэж тайлбарласан байна.

Үглэвэр	Өөрөөр хэлбэл	Үглэвэр	Оюутан өөрөөр хэлбэл, суралцагч
		Өгүүлбэр	Оюутан өөрөөр хэлбэл, Номин бол их сургуулийн суралцагч.
		Цогцолбор	Оюутан өөрөөр хэлбэл, Номин бол их сургуулийн суралцагч. Тэрээр Монгол Улсын Их Сургуулийн биологийн хөтөлбөрийг сонгон суралцаж буй хүн.
Өгүүлбэр	Өөрөөр хэлбэл	Үглэвэр	Номин бол Монгол Улсын Их Сургуулийн суралцагч, өөрөөр хэлбэл оюутан.
		Өгүүлбэр	Номин бол их сургуулийн суралцагч юм. Өөрөөр тэр их сургуулийн оюутан.
		Цогцолбор	Номин бол суралцагч. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Их Сургуулийн оюутан. Тэрээр биологийн хөтөлбөрийг сонгон суралцаж буй хүн.
Цогцолбор	Өөрөөр хэлбэл	Үглэвэр	Номин бол суралцагч. Тэрээр Монгол Улсын Их Сургуулийн биологийн хөтөлбөрийг сонгон суралцаж буй хүн. Өөрөөр хэлбэл, оюутан.
		Өгүүлбэр	Номин бол суралцагч. Тэрээр Монгол Улсын Их Сургуулийн биологийн хөтөлбөрийн сонгон суралцаж буй хүн. Өөрөөр хэлбэл, их сургуулийн оюутан.
		Цогцолбор	Номин бол суралцагч. Тэрээр Монгол Улсын Их Сургуулийн биологийн хөтөлбөрийг сонгон суралцаж буй хүн. Өөрөөр хэлбэл, биологич мэргэжилтэй болохоор шамдаж буй залуу. Монголын ирээдүй.

“Өөрөөр хэлбэл” холбоосын хэлний түвшинд илрэх харьцаа

Монгол хэл шинжлэлд холбоосыг *гадаад холбоос үг (гадна холбох үг), дотоод холбоос үг* гэж ангилан судалж ирсэн уламжлал бий. Тухайлбал, Д.Отгонсүрэн “Өгүүлбэрийн гадна холбоос бол нэг өгүүлбэрийг нөгөө өгүүлбэртэй, нэг догол мөрийг нөгөө догол мөртэй холбож, тухайн бичиг зохиолыг бичиж найруулахад өгүүлбэрийг дэс дарааг яв цав тогтоож, холбоо авцалдааг тодорхой болгодог тул үг холбох, энгийн өгүүлбэр холбох холбоосоос илүү найруулгын чухал үүрэгтэй бөгөөд бас тооны хувьд нөгөөдүүлээсээ харьцангуй их байна” (1978: 18), Ц.Өнөрбаян “холбох үгсийн үүрэг, харьцааг нарийн ажиглавал, нэг хэсэг нь хэлний тухайн хоёр нэгжийг зэрэгцүүлэн холбох, нөгөө хэсэг нь нэгийг нь нөгөөд нь захируулан холбодгоороо ялгарч байна”, “өгүүлбэрийг холбох үгсийн ихэнх нь нэг буюу хэд хэдэн өгүүлбэрээр илэрч байгаа утга санааг дараагийн нэг буюу хэд хэдэн өгүүлбэрээр илэрч байгаа утга санаатай холбох тул өгүүлбэрийн бүтцийн эхэнд тохиолдоно. Байрын энэ онцлогийг нь харгалзаж, эдгээрийг гадаад холбох үгс гэдэг” (1981: 91-99), З.Гулираанз “Хэл зүйн холбох хэрэглүүрүүдийг тохиолдох байрын талаас нь гадаад (“эх”-ийн хэсгүүдийг холбох), дотоод (үгэлбэрийн хэсгүүдийг холбох) гэж ангилахын зэрэгцээ үүргийн талаас нь зэрэгцүүлэн холбох, тодосгон холбох, нөхцөлдүүлэн холбох гэхчиглэн ангилж болно” (1995: 124) гэж тайлбарласан байна. Эх, түүний бүрэлдүүлбэрийг тодруулах, хэв маягийг тодорхойлох, холбоосын үгийг хэрэглээг судлахад дурдсан судалгаа үндсэн баримжаа болж иржээ.

Өөрөөр хэлбэл холбоос нь дээрх ангиллаар бол гадаад холбоос хэсэгт багтана. Гадаад холбоосын үүрэг, зорилгын талаар Б.Пүрэв-Очир “Гадаад холбох үгс нь ярианы ба бичгийн эхийн найруулгад маш чухал үүрэгтэй. Чухам хэрэгтэй газар нь зөв сонгож байрлуулбал, эх, мөчлөг, цогцолбор, өгүүлбэрийн тусгай ба нэгдмэл чанар, учир зүйн дараалал, хэл зүйн холбоо авцалдаа, өгүүлбэр зүйн айн утга, найруулгын хэм хэмжээ, тохироо зэргийг илтгэхэд машид чухал үүрэгтэй байдаг” (2014: 17) гэж тайлбарласан байна.

Өөрөөр хэлбэл холбоосыг уран зохиол, сонин нийтлэл, албан бичиг, шинжлэх ухаан, ярианы найруулгад тодорхой үүрэг зорилгоор хэрэглэнэ. Жишээ нь:

Жинхэнэ монгол эмэгтэйн төв дарууг баримтлагч болох нь илэрсэн бөгөөд үүнд нь ч хамаг

гоо сайхан нь нуугдаж байжээ. Өөрөөр хэлбэл, өнгө үзэмжийн гоо сайхнаас далдын гоо сайхан бол мөнхийн гоо сайхан байдгийг энд онцлон тэмдэглэе (Д.Намдаг).

Өөрөөр хэлбэл холбоосыг уран зохиолын эх, ялангуяа туульсын зохиолд аливаа юм үзэгдэл, түүний харьцаа хөдөлгөөнийг тайлбарлах зорилгоор тодорхой хязгаартай хэрэглэж болно. Мөн жүжгийн зохиол, түүний харилцан ярианд хэрэглэх нь бий. Харин харьцангуй чөлөөт бус найруулгын эхэд тохиромжтой энэхүү холбоосыг яруу найрагт хэрэглэхгүй.

Ховд аймагт хоёр хоногийн өмнө ирсэн, түүний PCR шинжилгээний хариу мөн сөрөг гарсан. Өөрөөр хэлбэл, 11 хүний шинжилгээнд коронавирусийн халдвар илрээгүй гэдгийг аймгийн Засаг дарга мэдээлж байсан юм (Өдрийн сонин).

Сонин нийтлэлийн бүтээлд *өөрөөр хэлбэл* холбоосыг нэлээд хэрэглэнэ. Тэр тусмаа нийтлэл, мэдээнд уг холбоосыг нийгмийн олон талт асуудал, түүнд холбогдох нэр томьёо, ухагдахуун, цаг хугацаа, орон зайг хавсарган тайлбарлах байдлаар хэрэглэж болно. Харин ярилцлага, хөрөг нийтлэлд сэдэв агуулгаас хамааран олон удаа давтахаас зайлсхийвэл зохино.

Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн текстийг харвал “зөвхөн нэг удаа сонгоно” гэж бий. Өөрөөр хэлбэл, “зөвхөн нэг удаа” гэдэг бол одоогийн Ерөнхийлөгч төдийгүй урьд өмнө Ерөнхийлөгчөөр сонгогдож байсан ямар ч иргэнийг Ерөнхийлөгчөөр дахин нэр дэвшүүлж болохгүй, дахин сонгож болохгүй гэсэн шууд, тодорхой, маргаангүй утгатай үг юм (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан).

Хурлын тэмдэглэл, ажлын тайлан, гүйцэтгэх төлөвлөгөө зэрэг зохион байгуулалтын албан бичгийн эхэд *өөрөөр хэлбэл* холбоосыг хэрэглэж болно. Харин захирамжлалын албан бичиг: Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын хууль, байгууллагын удирдлагын тушаал зэрэгт энэхүү холбоосыг хэрэглэхгүй. Учир нь дурдсан захирамжлалын бичиг нь товч, тодорхой, хоёрдмол утгагүй байх үндсэн шаардлага, хэм хэмжээнд нийцэх учиртай бөгөөд тайлбар, нэмэлтийг эшлэл, зүүлт, хаалт, хашилт зэргийг ашиглан бичнэ.

Дохионы анхдагч системд багтах байгалийн юм үзэгдэл нь байгалийнхаа зүй тогтлоор хөгжихийн явцад бүтэж эвдэрч байдаг бол дохионы хоёрдогч системд багтах хэлний дохионы янз бүрийн нэгж нь хүний нийгмийн хөгжлийн явцад мөн бүтэж эвдэрсээр иржээ. Өөрөөр хэлбэл, эвдрэхгүй бүтэх, бүтэхгүй эвдрэх юм үзэгдэл гэж ерөөс байхгүй, ямагт бүтэхийн хамт эвдэрч, эвдрэхийн хамт бүтэж байна гэсэн үг болно. Бүтэх эвдрэхийн аль аль нь шүтэн барилдаж байж сая бүтэж, эвдэрч болно (Ш.Лувсанвандан).

Өөрөөр хэлбэл холбоосыг шинжлэх ухааны найруулгын бүр төрлийн эхэд аливаа ухагдахуун, түүний мөн чанар, учир шалтгааныг хялбаршуулах, дэлгэрүүлэх, хураах зэргээр тайлбарлан хэрэглэнэ.

Манай сургууль хүүхдийг тэгш хөгжүүлэхэд нэн тэргүүнд анхаардаг. Өөрөөр хэлбэл, мэдлэг оюун, бие махбод, сэтгэлийн өв тэгш хүмүүжил олгохыг чухалчилдаг. Энэ ч утгаараа хүүхдийн бие махбодыг хөгжүүлэхийн тулд 33 төрлийн дугуйлан секц ажиллуулдаг (ikon.mn).

Ярианы найруулгын эрдмийн ярианы найруулгад *өөрөөр хэлбэл* холбоосыг өгүүлж буй санаагаа батлах, ойлгуулах, хялбаршуулах зорилгоор тодорхой хязгаартай хэрэглэнэ. Харин уг холбоос аман яриаг албархаг болгож мэдэх тул тохирох байрыг оновчтой сонгох шаардлагатай юм.

Өөрөөр хэлбэл холбоос, түүний хувилбар: *ондоогоор хэлбэл, нөгөөгөөр хэлбэл, өөр үгээр хэлбэл, өөр утгаар хэлбэл, нөгөө утгаар хэлбэл, нэг үгээр хэлбэл, энгийн үгээр хэлбэл* зэрэг холбоосыг ярианы найруулга, сонин нийтлэлийн найруулгад хоёр нэгжийг тэнцүүлж тайлбарлах үүргээр голлон хэрэглэнэ. Мөн шинжлэх ухааны хялбаршуулсан эхэд юм үзэгдэл, түүний харьцаа хөдөлгөөнийг харьцуулах, дэлгэрүүлэх байдлаар тайлбарлан хэрэглэж болно. Харин найруулгын бусад төрөлд дурдсан хувилбар холбоосыг хэрэглэхгүй.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын авто зам ачааллаа даахаа байлаа. Өөрөөр хэлбэл, хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, хот байгуулалтын байдлаас болоод агаарын бохирдол нэмэгдэж, амьдрах орчин нөхцөл муудаж байна.

Холбоосын утга, үүргийг ойлгоогүйгээс болж, бусад холбоосын утга, үүрэгтэй андуурч хэрэглэх тохиолдол гарах нь бий. Дээр дурдсан жишээнд буй эхний өгүүлбэрт авто замын ачааллын тухай, хоёр дахь өгүүлбэрт агаарын бохирдлын тухай өгүүлж байна. Хоёр өөр утга санааг илэрхийлж буй дохиог *өөрөөр хэлбэл* холбоосоор холбож болохгүй хэлний хэм хэмжээг зөрчсөн үзэгдэл болно. *Өөрөөр хэлбэл* гэдэг нь өгүүлснээс өөр агуулга, санааг илэрхийлэх утгагүй юм.

Утгачилбал хэмээх холбоос нь үгэлбэрийг өгүүлбэр, цогцолбортой; өгүүлбэрийг өгүүлбэр, цогцолбортой; цогцолборыг өгүүлбэр, цогцолбортой хурааж тайлбарлан холбоно. Харин хэлний их нэгжийг бага нэгжтэй холбохгүй.

...Эртний Ромын аугаа философич, хуульч Цэцэроны (МЭӨ 106-МЭӨ 43) “Хууль” бүтээлд байдаг “Хуулийн дээдийн дээд зорилго нь ард түмний сайн сайхны төлөө байх ёстой” гэсэн зарчим. Утгачилбал “Төрийн эрх мэдлийн үндсэн суурь нь ард түмний хүсэл эрмэлзлэл юм” (baabar.mn)

Эхний өгүүлбэрт буй санааг хоёр дахь өгүүлбэрт утгачлан буулгаж тайлбарлах арга нь нарийвчилбарын үндсэн хэсэг юм. *Утгачилбал* холбоосыг шинжлэх ухаан, сонин нийтлэл, ярианы найруулгад хэрэглэж болно. Харин албан бичиг, уран зохиолын найруулгад хэрэглэхгүй. Энэхүү холбоостой утгын хувьд төстэй, хувилбар болох *утга нь, ухаандаа, хар ухаанаар хэлбэл, ухаан нь* зэрэг холбоосыг А нэгжийг Б нэгжээр дэлгэрүүлж тайлбарлах ярианы найруулга, түүнчлэн уран зохиолын харилцан ярианд голлон хэрэглэнэ. Жишээ нь:

Монгол төрийн мэргэн зүтгэлтнүүд 1911 онд үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан юм. Ухаандаа, хамгийн боловсрол мэдлэгтэй, зориг зүрхтэй хүмүүс нэгдэн нийлж, үндэстнийхээ эрх ашгийг хамгаалж чадсан сан (лекц-яриа).

Миний бодлоор холбоосыг аливаа юм үзэгдэл, түүний харьцаа хөдөлгөөнийг хялбаршуулан тайлбарлах, харилцагчид энгийн, ойлгомжтой илтгэх, өгүүлэгчийн сэтгэл хөдлөл, хандлагыг тусган илэрхийлэх зорилгоор төгс ба төгс бус нэгжийг төгс нэгжтэй холбон хэрэглэнэ. Энэхүү холбоосыг сонин нийтлэл, ярианы найруулгад хэрэглэх бөгөөд ярианы найруулгын эрдмийн ярианы найруулгад хэрэглэхэд тохиромжтой. Харин албан бичиг, шинжлэх ухаан, уран зохиолын найруулгад хэрэглэхгүй.

Билгүүн дахин нэг сайхан ном хэвлүүлжээ. Миний бодлоор, түүний гаргасан ном нь хувь хүний дурсамжийг эсээ хэлбэрээр бичиж болохын үлгэр жишээ, басхүү сургамжтай олон баримтыг агуулсан шилдэг бүтээл (лекц-яриа).

Миний бодлоор холбоосыг *миний бодлоор бол, минийхээр бол, минийхээр, түүний бодлоор, түүний бодлоор бол, түүнийхээр* гэхчлэн энгийн болон нийлмэл хувилбар үүсгэж, төгс, төгс бус нэгжийг холбон бичиж болно.

Дүгнэлт

Тогтолцоот үүргийн хэл шинжлэлийн онолын хүрээнд холбоосжилтыг орхилт, орлуулалт, төлөөлүүлэл, үгийн сангийн холбомж, холбоос гэж ангилан судалж буй жишгээр монгол хэлний холбоос, түүний нэгэн дэд хэсэг: нарийвчилбарт хамаарах бататгах холбоосын зарим утгыг тайлбарлалаа. Жишээлж авсан *өөрөөр хэлбэл* холбоос нь юм үзэгдлийг үглэврийг үглэвэртэй холбон тайлбарлаж байгаа тохиолдолд хоёр үглэвэр харилцан ижил утгыг илтгэх бөгөөд хоёр дахь үглэвэр нь юм үзэгдлийн ерөнхий нэршлийг агуулсан учир эхний үглэвэрт хавсаргаж бататгасан үүрэгтэй ажээ.

Бататгах холбоос нь эхийн төрлөөс хамаарч харилцан адилгүй үүрэг гүйцэтгэж байна. Жишээлбэл, *өөрөөр хэлбэл* холбоосыг уран зохиолын эх, ялангуяа туульсын зохиолд аливаа юм үзэгдэл, түүний харьцаа хөдөлгөөнийг тайлбарлах зорилгоор тодорхой хязгаартай хэрэглэж болж байгаа бол яруу найргийн бүтээлд тохиолдохгүй байна.

Abstract

Within the theoretical framework of Systematic Functional Grammar, the cohesions are classified as ellipsis, substitution, reference, lexical cohesion, and conjunction. Accordingly, some meanings of Mongolian conjunctions, especially appositional conjunction, which is included in one of the subsections of the elaboration, have been explained.

In this article, the author explains the conjunction *ooroor khelbel* ‘in other words’. When this conjunction describes a lexeme with the meaning of a phenomenon by connecting it with another lexeme, the two lexemes give the same meaning, and the second lexeme contains the general denotation of the phenomenon, so it has a subordinating function to the first lexeme.

The appositional conjunction has different semantic functions depending on the text type.

Ном зүй

- Halliday, M.A.K., Hasan, Riquaya. 1976. *Cohesion in English*. London: Longman.
- Halliday, M.A.K., & Matthiessen, C. M. I. 2014. M. Halliday's *Introduction to Functional Grammar (Fourth Edition)*. London and New York: Routledge.
- Mann, W.C., Matthiessen, C.M.I.M., Thompson, S.A. 1992. Rhetorical Structure Theory and text analysis. In: Mann & Thompson (eds) 39–79.
- Thompson, G. *Introducing Functional Grammar (Third Edition)*. London and New York: Routledge. 225
- Отгонсүрэн, Д. 1978. Монгол хэлний холбоос үгийн найруулгын үүрэг. Улаанбаатар.
- Өнөрбаян, Ц. 1981. Орчин цагийн монгол хэлний холбоос, холбоос үгийн тухай. *УБИС-ийн эрдэм шинжилгээ, заах аргын бичиг*, 1(14): 91-99.
- Пүрэв-Очир Б, Мөнх-Амгалан, Гулираанз З. 1995. Монгол хэлний энгийн өгүүлбэр, эхийн онол-практикийн зарим асуудал. Улаанбаатар. 3: 124.
- Пүрэв-Очир Б. 2005. Монгол хэлний “өөрөөр хэлбэл” гэдэг холбоос үгийн бүтэц, утга, үүрэг, хэрэглээ. *МУИС-ийн МСТ-ийн Acta Mongolica*, 4(236): 57-65.
- Пүрэв-Очир Б. 2014. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй. Улаанбаатар.